

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН**

2022 оны 04 дүгээр сарын 04

Ховд

Ховд аймгийн Засаг дарга, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын төрийн захиргааны байгууллагад хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2014 оны А/363 дугаар захирамжаар баталсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын хүрээнд шийдвэрлэж, хуулийн хугацаанд нь багтаан хариу өгч ажиллав.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтын 9.2-д заасны дагуу сум, байгууллагуудыг өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдын албан тушаал, ажиллах журам, харилцах утас, тухай байгууллагын удирдлагуудын иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны байдлаар шинэчилж, цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулаад байна.

Сум, байгууллагуудаас ирүүлсэн 2021 оны жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, өргөдөл гомдол шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэр, мэдээлэл дамжуулах, шийдвэрлэх болон цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж боловсруулан хүргүүлэв.

Мөн Мөнххайрхан сумаас төрийн албаны шинэтгэл, шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, албан хаагчдын ажлын бүтээмж, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах, шинээр гарсан хууль, тогтоомжуудыг сурталчлах, төрийн албан хаагчдын манлайллыг дээшлүүлэх зорилгоор 3 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын II зөвлөгөөн”-нд оролцож буй 120 гаруй төрийн албан хаагчдад иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХӨТӨЙН ДАРГА НАРЫН ИРГЭДС ХӨСӨН АВАХ ЦЭГЭЙН ХУВААРЬ


Д/д	Албан тушаал	Овог-нэр	Өрөөний дугаар	Газар	Цагийн хуваарь
1	Аймгийн Засаг дарга	Б.Дугаржав	213	Пүрэв	09 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
2	Дэд бүтэц, иргэдийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, мэдээлэл, харилцах үйл ажиллагааны Засаг даргын дарга	Т.Жаргалсайхан	213	Мянхэр	09 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
3	Нийгмийн бодлогын асуудлыг хариуцсан Засаг даргын дарга	Т.Дэлгэрсайхан	218	Лалга	09 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
4	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	Д.Энхболд	209	Далаа	09 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
5	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Б.Ганболд	203	Өвөр Өр	10 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
6	Салеху, төрийн сангийн хэлтсийн дарга	М.Балдан	301	Өвөр Өр	10 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
7	Хууль, ёс хуулийн дарга	М.Балдан	217	Өвөр Өр	10 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
8	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, зарчмын зохицуулалтын хэлтсийн дарга	Б.Баярлах	211	Өвөр Өр	10 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
9	Амьтан-санхиргааны, уулзварын хэлтсийн дарга	Д.Арунболд	218	Өвөр Өр	10 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>
10	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Б.Гантөмөр	220	Өвөр Өр	09 <sup>00</sup> -12 <sup>00</sup> 13 <sup>00</sup> -16 <sup>00</sup>

-00-

хандан гаргасан өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэх, хяналт тавих, улирлын тайлан мэдээг нэгтгэх, тайлагнах талаар сургалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 149 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн байранд “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг эхлүүллээ.



Тус төвд 7 байгууллагын 14 албан хаагч байрлаж, төрийн үйлчилгээг нэг дороос иргэдэд хүргэн, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байна.

Үүнд: 1. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн хүүхдийн мөнгө, жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхэд асаргаа, ихэр хүүхэд, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж, нийгмийн халамжийн тэтгэвэр, хүүхдийн мөнгөн тэтгэмж, насны хишиг, ахмад настны тухай хуулийн хүрээнд олгох хөнгөлөлт, тусламж, үйлчилгээ, алдар цолтон, ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд олгох хөнгөлөлт, тусламж зэрэг үйлчилгээ үзүүлэх;

2. Улсын бүртгэлийн хэлтсийн 2 мэргэжилтэн төрөлт, гэрлэлт, нас баралт, иргэний үнэмлэх, үрчлэлтийн бүртгэл, шилжилт хөдөлгөөн, гарын хурууны хээний бүртгэл болон үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд бүх төрлийн лавлагаа олгох;

3. Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн зөвлөгөө мэдээлэл өгөх;
4. Татварын хэлтсийн мэргэжилтэн зөвлөгөө мэдээлэл өгөх
5. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2 мэргэжилтэн кадастрын зураг хэвлэх, үнэгүй газар өмчилсөн эсэх лавлагаа, газрын харилцаатай холбоотой цахим өргөдөл хүлээн авах болон газар эзэмших, өмчлөх, шилжүүлэх, эзэмшиж ашиглаж буй газрын талбайн хэмжээ өөрчлөх зэрэг асуудлаар мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх;
6. Жаргалант сумын оператор иргэдэд төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын систем [www.operator.e-mongolia.mn](http://www.operator.e-mongolia.mn)-ээр үйлчилгээ үзүүлэх;
7. 7043-1111 төв хариуцсан ажилтан иргэдийн эрэлт, хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч хариу хүргүүлэх ажлуудыг тус хариуцан ажиллаж байна.



Түүнчлэн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байранд “Эрх зүйн хөтөч”-ийн буланг шилжүүлэн байршуулснаар иргэд хууль, эрх зүйн болон төрийн байгууллагын үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг өөрөө авах нөхцөл боломжийг бүрдүүллээ.



Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг

дарга, түүний Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч 25 агентлаг, 11 байгууллага, 17 сумын Засаг даргын Тамгын газар, 86 төсөвт байгууллага, 91 баг, “Угтах үйлчилгээ-7043-1111 төв”-д ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын мэдээг 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэн гаргахад нийт 4816 өргөдөл, гомдол хүлээн авч, 4227 өргөдлийг шийдвэрлэн хариу өгч, 370 өргөдлийг холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж, 219 өргөдлийг шийдвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 97.4 хувьтай байна.

Тайлант хугацаанд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг эзлэх хувиар нь нөлөөлсөн хүчин зүйлсийг авч үзвэл:

1. Газар хүссэн өргөдөл гомдлын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлс:

1.1. Улсын хэмжээнд газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж байгаатай холбоотойгоор цахим системд иргэдийн газар эзэмших, өмчлөлийн газрын мэдээллийг оруулах, газрын хэмжээ талбай, хаягийн зөрчлийг арилгуулах ажил явагдаж байна.

1.2. Засгийн газрын 2022 оны 121 дүгээр тогтоолоор иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт батлагдсантай холбоотойгоор газар өмчлөх хүсэлт гаргасан иргэдийн өргөдлийг хүлээн авч эхэлсэн. Эдгээртэй холбоотойгоор газрын талаарх өргөдөл, гомдлын тоо нэмэгдэж, нийт өргөдлийн 24.2 хувийг эзэлж байна.

2. Улсын бүртгэлийн үйлчилгээнд хамруулж өгөхийг хүссэн өргөдөл гомдлын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлс:

2.1 Иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний үнэмлэх шинээр авах, сунгалт хийлгэх, дахин авах, төрөлт, үрчлэлт, гэрлэлт, нас барсны бүртгэл хийлгэх болон иргэний бүртгэлийн лавлагаа авах хүсэлт голлох хувийг эзэлж байна.

3. Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл гомдлын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлс:

2.1. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг тэтгэвэр, тэтгэмж, халамжийн үйлчилгээ бүрэн цахимжсантай холбоотойгоор цахим санд зөрүүтэй орсон иргэдийн мэдээллийг засаж, залруулан, мэдээллийг шинэчлэх ажил үргэлжлэн хийгдэж байгаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо нэмэгдсэн бөгөөд 8.7 хувийг тус тус эзэлж байна.

**ХОВД АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН  
ТУШААЛТАНД 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН  
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

2022 оны 04 дүгээр сарын 04

Ховд

Д/д	Сум, байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт (хувь)
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэлж	Хугацаа болоогүй	
1	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	4	1	3			100%
2	Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар	120	95	25			100%
3	Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагууд, баг	3959	3459	326		174	95.6%
4	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн байгууллагууд	733	672	16		45	93.9%
Нийт дүн		4816	4227	370		219	97.4%

Хүснэгт 2

**ХОВД АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,  
АЛБАН ТУШААЛТАНД 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД ИРГЭДЭЭС  
ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ (хэлбэрээр)**

2022 оны 04 дүгээр сарын 04

Ховд

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдол, санал, хүсэлт	Үүнээс					Бусад
			бичгээр	11-11 төвөөр	Цехим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	
1	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	4	4					
2	Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар	120	74	2	20		24	
3	Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагууд, баг	3959	3500		77	30	352	
4	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн байгууллагууд	733	678		27	24	4	
Нийт дүн		4816	4256	2	124	54	380	

## ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА (хувиар)

2022 оны 04 дүгээр сарын 04

Ховд

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудал (тоо, нийт өргөдөл, гомдол эзлэх хувь)					
1	Ховд аймаг	Нийт: 4816 өргөдлөөс		1. Хүсэлт	4456	92,5 %	
				2. Санал	289	6,0 %	
				3. Гомдол	71	1,5 %	
						Тоо	Хувь
		Бусад асуудлаар				1247	25,9
		Газар хүссэн				1166	24,2
		Улсын бүртгэлийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн				642	13,3
		Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдахыг хүссэн				420	8,7
		Ажилд оруулж өгөхийг хүссэн				414	8,6
		Байгууллагын алба хаагчдаас чөлөө хүссэн				340	7,1
		Нийгмийн даатгалын чиглэлээр				334	6,9
		Татвар, И баримтын талаар				101	2,1
		Буцалтгүй тусламж олгож өгөхийг хүссэн				67	1,4
Зээл, төсөлд хамруулж өгөхийг хүссэн				63	1,3		
Гэр олгож өгөхийг хүссэн				22	0,5		

Үүнээс:

1. Газар хүссэн өргөдөл гомдлын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлс:

1.1. Улсын хэмжээнд газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж байгаатай холбоотойгоор цахим системд иргэдийн газар эзэмших, өмчлөлийн газрын мэдээллийг оруулах, газрын хэмжээ талбай, хаягийн зөрчлийг арилгуулах ажил явагдаж байна.

1.2. Засгийн газрын 2022 оны 121 дүгээр тогтоолоор иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт батлагдсантай холбоотойгоор газар өмчлөх хүсэлт гаргасан иргэдийн өргөдлийг хүлээн авч эхэлсэн. Эдгээртэй холбоотойгоор газрын талаарх өргөдөл, гомдлын тоо нэмэгдэж, нийт өргөдлийн 24.2 хувийг эзэлж байна.

2. Улсын бүртгэлийн үйлчилгээнд хамруулж өгөхийг хүссэн өргөдөл гомдлын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлс:

2.1 Иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний үнэмлэх шинээр авах, сунгалт хийлгэх, дахин авах, төрөлт, үрчлэлт, гэрлэлт, нас барсны бүртгэл хийлгэх болон иргэний бүртгэлийн лавлагаа авах хүсэлт голлох хувийг эзэлж байна.

3. Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдахыг хүссэн өргөдөл гомдлын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйлс:

2.1. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг тэтгэвэр, тэтгэмж, халамжийн үйлчилгээ бүрэн цахимжсантай холбоотойгоор цахим санд зөрүүтэй орсон иргэдийн мэдээллийг засаж, залруулан, мэдээллийг шинэчлэх ажил үргэлжлэн хийгдэж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР